



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/55

Шивээговь сум

Багийн Засаг дарга нарыг чадавхжуулах
сургалт зохион байгуулах комисс
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Шивээговь, Сүмбэр, Баянтал сумдын багийн Засаг дарга нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

- | | |
|-----------------|--|
| Комиссын дарга: | Ц.Цэрэндорж
(Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч) |
| Гишүүд: | Д.Сувд-Эрдэнэ
(1 дүгээр багийн Засаг дарга)
С.Отгонбаатар
(2 дугаар багийн Засаг дарга)
Б.Алтансүх
(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
Д.Отгонбаатар
(Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн) |

Б.Мөнхцэцэг

(Нярав)

Нарийн бичгийн дарга:

Г.Наранбаатар

(Соёлын төвийн техникч, Спортын арга
зүйч)

2. Сургалтын удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, сургалтын зардалд зарцуулагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалтанд зарцуулагдах 600,000 (зургаан зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

4. Сургалтанд багийн Засаг дарга нар болон ажилтан, албан хаагчдыг хамруулж, чадавхжуулах мэдлэг олгоход уриалан өндөр түвшинд зохион байгуулалттай ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэндорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын 2022 оны 04-р сарын 25-ны өдрийн 4/55 дугаар захирамжийн 1-р хавсралт

ШИВЭЭГОВЬ СУМАНД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ГУРВАН СУМЫН БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫГ МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТАНД ОРОЛЦОГЧ НАРЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ "НӨХӨРСӨГ ТЭМЦЭЭНИЙ"-ЫН УДИРДАМЖ
Арга хэмжээнд оролцогч иргэд оролцоно

Наадмын зорилго: Ажилтан албан хаагчид, багийн Засаг дарга нарын бие бялдарыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх, хамт олныг нэгтгэн төлөвшүүлэх, мэргэжил нэг нөхөдтэйгөө танилцах хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Спортын төрөл, бүрэлдэхүүн

№	Спортын төрөл	Багийн бүрэлдэхүүн	Зохион байгуулах	Зохион байгуулах газар
Үндсэн төрөл				
1	Гар бөмбөг	Эрэгтэй-4, эмэгтэй-3 тус бүр 1 дасгалжуулагчтай	15 оноогоор 2 ээлж	Уурхайн зааланд
2	Буухиа	Эрэгтэй- 2 Эмэгтэй-2		Уурхайн зааланд
3	Даам	Эрэгтэй Эмэгтэй	Хасагдах системээр	Уурхайн зааланд

1.2 Спортын наадмын тов

Спортын наадам 2022 оны 04 сарын 26-ний 16⁰⁰ цагаас эхэлнэ

1.3 Техникийн зөвлөгөөн

Техникийн зөвлөгөөн нь 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 15⁰⁰ цагт Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд болно Тус техникийн зөвлөгөөнд зохион байгуулах ажлын хэсэг багийн ахлагч нар оролцоно.

Техникийн зөвлөгөөнд багийн ахлагч нар тэмцээнд оролцох баг тамирчдыг арга хэмжээнд оролцогч нараас сугалж багаа бүрдүүлэнэ.

Хоёр. Тэмцээн зохион байгуулах, дүгнэх журам

2.1 Тэмцээнд оролцох баг тамирчид багийн ахлагчтай байна

2.2 Тэмцээний үеэр ямар нэгэн маргаан гарсан тохиолдолд тамирчид багийн ахлагчаар дамжуулан тухайн маргааныг шийдвэрлүүлнэ.

2.6 Тоглолтын дэг, хуваарь, эхлэх болон дуусах дарааллыг техникийн зөвлөгөөн дээр сугалаагаар тогтооно

2.8 Багийн нийлбэр оноогоор 1-3 байр эзэлүүлнэ.

Сумын Засаг даргын 2022 оны 04-р сарын 25-ны өдрийн 155 дугаар захирамжийн 2-р хавсралт



ШИВЭЭГОВЬ СУМАНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ГУРВАН СУМЫН БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫГ МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ТӨСӨВ

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэ бүрийн үнэ	Нийт дүн
1	Жааз	ш	3	7500	22500
2	Бичгийн цаас	ш	2	15000	30000
3	Фото цаас	боодол	1	11500	11500
4	ус	ш	30	800	24000
5	кофе	ш	30	500	15000
6	Чихэр	Кг	3	12000	36000
7	Тэмдэглэлийн дэвтэр	ш	30	10000	300, 000
8	Бал	ш	30	1500	45000
9	маск	ш	30	1000	30000
10	1-р байр Шагнал	ш	1	40000	40000
11	2-р байр Шагнал	ш	1	30000	30000
12	3-р байр Шагнал	ш	1	16000	16000
13	Нийт дүн	-	-	-	600,000